



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ЗАХИРГААНЫ АКТЫГ МЭДЭГДСЭН ТУХАЙ ХУУДАС

2025 оны 03 сарын 12-ны өдөр

Шаамар сумын Засаг даргын өрөө
/үйсдэгт газар/

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Одсүрэн би Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын хорооны 2025 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дугаартай удирдамж”-ын хүрээнд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус /доогуур зурах/ дотоод аудитыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэр, удирдамжийн хүрээнд /доогуур зурах/ зохион байгууллаа

Дотоод аудитыг Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023-2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн үйл ажиллагааны аудит, гүйцэтгэлийн /доогуур зурах/ чиглэлээр явуулсан ба дотоод аудитаар 2024 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт гэрээний үнийн дүнгийн 5 хувиар гүйцэтгэлийн баталгаа гаргахаар шаардсан боловч тендэрт гүйцэтгэгчээр шалгарсан ЭЛ СИ БИ ХХК-тай 191,000,000 төгрөгийн гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 5,730,000.0 (Таван сая долоон зуун гуч) төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй зөрчилд Улсын байцаагчийн зөрчлийг арилгуулах тухай албан шаардлага (шалгалтын тэмдэглэл, улсын байцаагчийн акт, албан шаардлага) хүргүүлэхээр шийдвэрлэснийг Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийг удирдлага болгон Шаамар сумын Засаг дарга М.Ганболд болон Ерөнхий нягтлан бодогч Т.Номинчимэг нарт дараах арга хэлбэрээр 2025 оны 03 сарын 12-ны өдрийн 10 цаг 05 минутад мэдэгдэв.

✓ Хэлбэр

Тайлбар

✓ Өөрт нь гардуулах

☐ Утсаар

☐ Бусад

Захиргааны актыг мэдэгдсэн эсэх талаар нотломж:

Хяналт шалгалтын тэмдэглэл бүхий 15 хуудас, Улсын байцаагчийн албан шаардлага, гардуулсан тэмдэглэлийн хамт.

МЭДЭГДСЭН:

Сэлэнгэ аймгийн санхүүгийн хяналт
дотоод аудитын газрын дарга, /СХШУАБ/

Т.Одсүрэн

МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭН АВСАН:

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын засаг дарга
Ерөнхий нягтлан бодогч

М.Ганболд

Т.Номинчимэг





СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 02/32-У

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023-2024 оны жил ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар 2024 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт гэрээний үнийн дүнгийн 5 хувиар гүйцэтгэлийн баталгаа гаргахаар шаардсан боловч тендерт гүйцэтгэгчээр шалгарсан ЭЛ СИ БИ ХХК-тай 191,000,000 төгрөгийн гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 5,730,000.0 (Таван сая долоон зуун гуч) төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 42.2-д "Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана", "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 3.1 дэх "Хуулийн 42.1-д зааснаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас багагүй үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчид хүргүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ," гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

4025007005

1. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байх төрийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Шаамар сумын Засаг дарга М.Ганболд, Ерөнхий нягтлан бодогч Т.Номинчимэг нарт даалгав.
2. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ

Т.ОДСҮРЭН



ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР
СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ГАНБОЛД
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
Т.НОМИНЧИМЭГ

